



ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ ЗДТГАЗАР

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

[И-мэйл](#)

Аудитын багийн ахлагч Аудитор

Ц.Базарсад

Утас: 70272287

И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	6
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	7

ЗДТГазрын 2013 оны санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид ЗДТГазрын 2013 оны санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба ЗДТГазрын төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын ЗДТГазрын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Аймгийн МХГазрын төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт 2014 оны 1-р сард хийгдсэн тул хяналт шалгалт аудитыг санхүүгийн тайлан, журналд түшиглэн анхан шатны баримтыг үзээгүй болно.
2. ЗДТГазрын Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 173990700 төгрөг, орон нутгийн төсвөөс 29976719, үндсэн бус үйл ажиллагааны орлого 63632920 нийт 267600339 төгрөгийн эх үүсвэр тайлагнагдсан. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал санхүүжилт 173990700 төгрөг, орон нутгийн төсвөөс 29976719, үндсэн бус үйл ажиллагааны орлого 63772920, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 3086968,1, хөрөнгийн орлого 75951402 нийт 346778709,1 төгрөгийн орлого тайлагнагдсан байна. Үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлогыг үр дүнгийн тайланд үнэн зөв тайлагнасан байна.
3. Тайлант онд нэмэлт төсвийн дансанд 18234735 төгрөгийн орлого

- орж нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсэн амаржсны тэтгэмжинд 1585980, байгаль хамгаалагчийн цалинд 7768995, ахмадын хороон даргын урамшуулалд 270000, аймгийн 90 жилийн ойн сүүдрэвчний үнэ 1000000, мал эмнэлэгийн үйлчилгээний хөлс 3609700, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн багийн даргын тэтгэмж 2650200, шатахуунд 390060, томилолт 894000, засаг даргын зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 215940 төгрөгийг тус тус зарцуулсан байна.
4. Цалингийн санд 134025300 төгрөг батлагдснаас 134025300 төгрөг зарцуулж хэтрэлт хэмнэлт гараагүй байна. Цалингийн сангаас өөр зардалд шилжүүлсэн болон гарсан зардал байхгүй байна. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны мэргэшлийн түвшинг үнэлэн түүнийг үндэслэн Тамгын газрын даргын тушаалаар үр дүнгийн урамшууллыг ажлын үр дүнг харгалзан эхний хагас жилд 9 хүнд 815829 төгрөгийн урамшуулал олгосон байна.
 5. Жилийн эцсийн тооллогыг сумын Засаг даргын захирамжаар төсөвт байгууллагуудын нягтлан бодогч болон өмч хамгаалах зөвлөлийн 1 гишүүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилон тухайн байгууллагуудын ажилтнуудыг сэлгэн тооллого хийлгэсэн байна. Тооллогыг тооллогын комисс хөрөнгийн нэр төрлөөр тооллогын бүртгэл хөтлөн хурлын тэмдэглэл хөтлөн дүгнэлт гаргаж тайлагнасан байна.
 6. Тайлант онд бичиг хэргийн зардалд 884900 төгрөг, шуудан холбооны зардалд 230000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 7500000 төгрөг нийт 8614900 төгрөг батлагдснаас бичиг хэргийн зардалд 797775 төгрөг, шуудан холбооны зардалд 305655 төгрөг, тээвэр шатахууны зардалд 7511470 төгрөг, нийт

8614900 төгрөгийн зардал гаргасан байна. Үр дүнгийн тайлангаар бичиг хэргийн зардал 899343 төгрөгөөр БМ-ын тодоруулгын тайлангаар 786726 төгрөгөөр тайлагнагдсан. Энэ нь шуудан холбооны зардлаас бичиг хэргийн материал авч шууд зардалд бичсэн байна.

7. Зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс зардлыг санхүүжүүлэхдээ бичилтийн алдаа гаргасан байна.
8. Шатахууныг олгохдоо замын хуудсыг үндэслэн шатахуун олгох зөвшөөрлийн бичгээр олгож сарын эцэст тооцоо нийлэн төлбөрийг шилжүүлдэг. Тайлан гаргахдаа жолоочийн тооцоо боддоггүй зөрчил илэрсэн.
9. Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 6.4-д заасныг үндэслэн "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор баталласан. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах ба тус журамд нийцүүлэн аж ахуйн нэгж байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналтын журам"-ыг боловсруулаагүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтанг томилон ажиллуулаагүй байна.

Ерөнхий менежерээс ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар

Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

- Ерөнхий Аудитор 2014.03.18-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Э.Эрдэнэжаргал бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.14

Танилцуулга

1. Бид Аймгийн Баянцогт сумын ЗДТГазрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Баянцогт сумын ЗДТГазрын ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын ЗДТГ тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баянцогт сумын ЗДТГазрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Баянцогт сумын ЗДТГазрын тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Баянцогт сумын ЗДТГазрын удирдлагын анхаарлыг хандуулж байна:
 1. **Санхүүгийн дотоод хяналтын талаар**
 - Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 6.4-д заасныг үндэслэн “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор баталласан. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах ба тус журамд нийцүүлэн аж ахуйн нэгж байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналтын журам”-ыг боловсруулж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтанг томилон ажиллуулаагүй байна.
 2. **Орлогын талаар**
 - Батлагдсан төсвийн санхүүжилтыг 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад санхүүжилт 19633,3 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос 10,6 %-иар өссөн нь хувьсах зардал нэмэгдсэн, цалин өссөнтэй холбоотой байна.
 - Орлого санхүүжилтийг мөнгөн харилцахын журналаас SORT FILTER-ийг ашиглан эх үүсвэрийг бүрэн ангилан тусгасныг шалгахад орлого, санхүүжилтийг бүрэн бүртгэсэн байна.

- 2013 оны Батлагдсан төсөв 203967419 төгрөгийг бүрэн авч, хөрөнгийн орлого 75951402 төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 3086968,1 нэмэлт санхүүжилтээр 63772920 төгрөгний эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

- Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн 140855001 тоот дансаар 173990700 төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 29976719, нэмэлт санхүүжилтээр 63632920, буцсан орлого 3456403, 271056742 төгрөгийн зарлага гарч 0 төгрөгийн үлдэгдэлтэйгээр Төрийн сангийн төлөөлөгч баталгаажуулсан байна.
- Харилцахын баримтын бүрдэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт сайн байна. Сар бүрийн мэдээг программ хангамжаар гаргаж байгааг хяналтын түвшингийн хуулгатай тулган шалгахад сарын мэдээндээ байгууллагын өр, авлагыг тогтмол тулгаж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

4. Бараа материалын талаар

- Бараа материалын эхний үлдэгдэл 16019328,3 төгрөг тайлангаар төсвийн хөрөнгөөр 27693039 төгрөг, хандиваар 1743724,9 мянган төгрөг бүгд 29436763,9 төгрөгийн орлого нэмэгдэж, 22719382 төгрөг зарцуулж 412170 төгрөгний бараа материалыг сумын ИТХТ-ийн 2013.08.29-ны 66 тоот тогтоолоор акталж устгасан байна. Бараа материалын үлдэгдэл, санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл, тодруулгын тайлангийн үлдэгдлийг тулган шалгахад зөрүү гараагүй.
- Бараа материалын тооллогыг цаг хугацаанд хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Бараа материалын үлдэгдэл няравын материалын үлдэгдэлтэй зөрүүгүй таарч байна.

5. Үндсэн хөрөнгийн талаар

- Жилийн эцсийн тооллогыг сумын Засаг даргын захирамжаар төсөвт байгууллагуудын нягтлан бодогч болон өмч хамгаалах зөвлөлийн 1 гишүүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилон тухайн байгууллагуудын ажилтнуудыг сэлгэн тооллого хийлгэсэн байна. Тооллогыг тооллогын комисс хөрөнгийн нэр төрлөөр тооллогын бүртгэл хөтлөн хурлын тэмдэглэл хөтлөн дүгнэлт гаргаж тайлагнасан байна.
- Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 776993.2 мянган төгрөг, тайлант онд 77943.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, данснаас 11892.0 мянган төгрөгний хөрөнгө актлагдаж оны эцэст 843044.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Нэмэгдсэн хөрөнгөнд төсвийн хөрөнгөөр 649,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй хүлээн авсан 77294,6 мянган төгрөгийн хөрөнгөнөөс 55832,5 мянган төгрөгийн барилга байгууламж, 15500,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 5838,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 120,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмэгдэж, ИТХТ-ийн 2013.08.29-ны 66 тоот тогтоолоор 11066,1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 825,8 мянган төгрөгийн тавилга эд хогшил актлагдсан байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөнөөс орон нутгийн хөгжлийн сангаас 45436,9 мянган төгрөгийн хөрөнгө, байгаль хамгаалах сангаас 970,0 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн хөрөнгө оруулалтаар 27998,7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнийг данс бүртгэлд авсан эд хөрөнгийн картаар эзэнжүүлж өгсөн байна.
- Үндсэн хөрөнгийн Элэгдлийн тооцооллыг программаар зөв бодсон байна.

6. Бараа үйлчилгээний зардал

- Бараа үйлчилгээний зардал нь бүрэн зарцуулагдаж төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 37096,9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүний 54,3 хувь буюу 20168,1 мянган төгрөг нь тогтмол зардал эзлэж байна.

- Нүүрсний тооцооллыг тодруулбал:
- Ц.Жигмэддоржоос тайлант онд 206 тн буюу 16500.0 мянган төгрөгийн нүүрс бэлтгэж 165 тн буюу 12858.0 мянган төгрөгийн нүүрс зарцуулж 75.9 тн буюу 6072.0 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй гарсан байна. Нэг цагт 30 кг хоногт 720 кг жилдээ 174.2 тн зарцуулахаас норм, нормативын дагуу зарцуулсан байна.
Тайлант онд бичиг хэргийн зардалд 884900 төгрөг, шуудан холбооны зардалд 230000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 7500000 төгрөг нийт 8614900 төгрөг батлагдснаас бичиг хэргийн зардалд 797775 төгрөг, шуудан холбооны зардалд 305655 төгрөг, тээвэр шатахууны зардалд 7511470 төгрөг, нийт 8614900 төгрөгийн зардал гаргасан байна. Үр дүнгийн тайлангаар бичиг хэргийн зардал 899343 төгрөгөөр БМ-ын тодруулгын тайлангаар 786726 төгрөгөөр тайлагнагдсан. Энэ нь шуудан холбооны зардлаас бичиг хэргийн материал авч шууд зардалд бичсэн байна.

7. Авлага, өглөгийн талаар

- НДаатгал, Холбоо, Петровис ХХК-тай тооцоо нийлж өр, авлагагүйг баталгаажуулсан байна.
- Байгууллагуудын өглөг, авлагын журналыг, харилцахын журнал, бараа материалын тодруулгын тайлангийн орлогуудтай тулган шалгахад зөрүү гараагүй.
- Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтэрийн данстай тулган баталгаажуулсан.
- Тайлант онд тамхины зөвшөөрөлийн буцаан олголтын 140.0 мянган төгрөгийн өглөгтэй, жилийн эцсээр үлдэгдэл татагдахад тамхины зөвшөөрөлийн буцаан олголтын 140.0 мянган төгрөг татагдсан учир мөн 140.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

8. Цалингийн талаар

- Тайлант онд 27 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсанаас удирдах-1, гүйцэтгэх-10, үйлчилгээний-10, гэрээт 4 хүн нийт 27 оронтой үйл ажиллагаа явуулсан байна.
- Ажилтнуудын цалинг ЗГ-аас гаргасан сүлжээнд нийцүүлэн тогтоосон, бичигдсэн цалин НББ-ийн журнал, СХТ-ийн тоо дүнтэй тохирсон, цалингаас суутган тооцоо хийж байгаа тооцоолол үнэн зөв хийгдэж байна.
- Гэвч ЗДТГ-ын дарга Н.Уранцэцэг нь 2013 оны 11 сараас эхлэн Засаг даргын захирамжгүйгээр өөрийн цалингийн шатлал ахиулан 148,2 мянган төгрөгийг илүү авсан, ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдэлд 934,2 мянган төгрөг илүү олгосон нь зөрчил илэрсэн байна. Үүнд 2014 оны 1-р сард МХГазрын санхүүгийн шалгалтаар төлбөр тавигдсан байна. Мөн 1-5 сард галч нарт илүү цагийн хөлс олгоогүй 974,2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь МХГазрын шалгалтаар акт бичигдсэн байна..

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ЗГазрын 2011.11.09-ний 311 тоот тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг мөрдөж байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулан үр дүнг тооцож ажиллах
- Төсвийн бүрдүүлэлт зарцуулалтанд төсвийн тухай хуулийг баримтлаж ажиллах
- Шатахууныг олгохдоо замын хуудсыг үндэслэн шатахуун олгох зөвшөөрлийн бичгээр олгож жолоочийн тооцоо бодох

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Баянцогт сумын ЗДТГазар авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7.Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

8.Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд ЗДТГазрын удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн аудитын газар
2014.03.14